

“Монголын төмөр зам” Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
28 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт



“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо (цаашид “Хороо” гэх)-ны үйл ажиллагаа, гишүүдийн эрх, үүрэг болон хурал зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ

2.1. Хороо нь дараах чиг үүрэгтэй:

2.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

2.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

2.1.4. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.5. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

2.1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

2.1.7. Шинээр сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд түүний үүрэг, хариуцлагыг тодорхой заасан удирдамж, зааварчилгаагаар хангах;

2.1.8. Удирдах албан тушаалтны залгамж халааг төлөвлөж, хэрэгжүүлэх бодлого боловсруулах.

2.2. Хорооны гишүүн дараах үүрэгтэй:

2.2.1. Хорооны хуралд идэвхтэй оролцох;

2.2.2. Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээллийн нууцыг хадгалах;

2.2.3. Хараат бус гишүүний статус нь ямар нэг хэмжээгээр өөрчлөгдөх, эсхүл тодорхой асуудлыг хэлэлцэх, дүгнэлт гаргахад аливаа ашиг сонирхлын зөрчилтэй байгаа тохиолдолд энэ тухайгаа Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлэх.



ГУРАВ. ХОРООНЫ ЭРХ

3.1. Хороо нь дараах эрх эдэлнэ:

3.1.1. Компанийн эрх бүхий албан тушаалтнаас баримт бичиг, илтгэл тайлан, тайлбар болон холбогдох мэдээлэл гаргуулан авах;

3.1.2. Компанийн зохион байгуулалтын нэгж, ажилтныг хорооны хуралд оролцуулж, тайлбар, тодруулга авах;

3.1.3. Үйл ажиллагааны үр дүн, тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд улирал тутам тайлагнах, зайлшгүй гэж үзвэл шаардлагатай асуудлыг цаг алдалгүй Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

3.1.4. Жилийн үйл ажиллагааныхаа тайланг хэлэлцэж /энэхүү журмыг хэрхэн хэрэгжүүлж ажилласан, биелүүлсэн асуудлыг хамааруулсан/ үнэлэлт, дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах.

ДӨРӨВ. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН БА ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ЧӨЛӨӨЛӨХ

4.1. Хороо нь сондгой тоотой гишүүнтэй байх ба гишүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн олонхын саналаар сонгоно. Зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй.

4.2. Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаатай адил байна.

4.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус гишүүдийг хорооны гишүүнээр сонгох зарчмыг баримтлах бөгөөд хорооны гишүүдийн 2/3 нь заавал хараат бус гишүүнээс бүрдэнэ.

4.4. Хорооны гишүүд компанийн үндсэн удирдлага болон бусад холбогдох ажилтнуудтай харилцан ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, туршлагатай байна.

4.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь хорооны гишүүнийг чөлөөлөх эсхүл хорооны бүрэлдэхүүнийг бүхэлд нь шинэчлэх эрхтэй.

ТАВ. ХОРООНЫ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1. Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд гишүүдийн олонхын саналаар томилогдсон дарга хороог удирдана.

5.2. Хурлыг хорооны дарга, аль нэг гишүүн, эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр зарлан хуралдуулна. Хорооны гишүүдийн энгийн олонх оролцсоноор хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.

5.3. Хороо нь хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцвэл хорооны даргын саналыг харгалзан үзнэ.

5.4. Хороо нь хэлэлцсэн асуудлаараа зөвлөмж, дүгнэлт гаргана.

5.5. Хорооны үйл ажиллагаа, үүргийг цаг хугацаа алдалгүй хэрэгжүүлэх үүднээс хорооны хурлыг ажлын болон ажлын бус цагаар хуралдуулж болно. Хороо нь улиралд нэгээс доошгүй удаа заавал хуралдана.

ААТАР

ГОЛЬ
ЭР ЗА
ЭХК

090377
СТА3

5.6. Хорооны хурлыг гишүүд биечлэн оролцох, эчнээ санал өгөх хуудсаар оролцох, цахимаар оролцох хэлбэрээр явуулж болно.

5.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хорооны хурлын тов, хэлэлцэх асуудлыг гишүүдэд урьдчилан мэдэгдэж, шийдвэрийн төсөл, холбогдох материалыг хүргүүлэх ба хурал болохоос 3 өдрийн өмнө хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон асуудалтай холбоо бүхий шаардлагатай мэдээллийг гишүүдэд хүргүүлнэ.

5.8. Хорооны хурлаас гарах зөвлөмж, дүгнэлтэд хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтөлнө. Хорооны аль нэг гишүүн олонхоос өөр саналтай байсан бол түүнийг хамтад нь хүргүүлнэ.

-----oOo-----

